

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах хүрээнд хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд зайны хяналт, газар дээрх шалгалт хийж, санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

Хоёр. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төрөл, ангилал

2.1. ХЗХ-ны үйл ажиллагаанд хийх эрсдэлд суурилсан хяналт шалгалт нь зайны хяналт, газар дээрх шалгалт гэсэн төрөлтэй байна.

2.2. Зайны хяналтыг Хорооноос баталсан “Эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу гүйцэтгэж, дүгнэлт өгнө.

2.3. Газар дээрх шалгалтыг үйл ажиллагааны хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна.

2.3.1. Иж бүрэн шалгалтаар Хорооноос баталсан хуваарь, удирдамжийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий байгууллага болон хадгаламж, зээлийн хоршооны баталсан журам, дүрэм, заавар болон бусад шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад тулгуурлан ХЗХ-ны үйл ажиллагааг бүхэлд нь шалгаж дүгнэлт өгнө.

2.3.2. Хэсэгчилсэн шалгалт нь зах зээлийн оролцогч, ХЗХ-ны гишүүн, холбогдох бусад байгууллагаас ирсэн мэдээлэл, өргөдөл, гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн мөрөөр, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд баталсан удирдамжийн хүрээнд ХЗХ-ны үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж дүгнэлт өгнө.

Гурав. Зайны хяналт

3.1. Зайны хяналтыг Хорооны улсын байцаагч, хянан шалгагч гүйцэтгэнэ. ХЗХ-ны ирүүлсэн санхүүгийн тайлан, мэдээг хянаж, үйл ажиллагааны эрсдэл болон үүсэж болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоож, санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд нь үнэлгээ, дүгнэлт өгнө.

3.2. Санхүүгийн тайлан, мэдээллийг ирүүлээгүй, ирүүлсэн санхүүгийн тайлан, мэдээлэл нь шаардлага хангаагүй бол ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтнаас шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардана.

3.3. Энэхүү журмын 2.2-т заасан аргачлалын дагуу ХЗХ-ны эрсдэлийн үнэлгээг тайлант жилийн дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний түвшин бүрээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4. Улсын байцаагч, хянан шалгагч нь тухайн ХЗХ-ны эрсдэлийг үнэлж, жилийн эцсийн тайлангийн хариуг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор журмын 1 дүгээр хавсралтын дагуу бичгээр хүргүүлнэ.

3.5. Тухайн ХЗХ-г хариуцсан улсын байцаагч, хянан шалгагч нь шаардлагатай гэж үзвэл дараалсан хяналтыг хэрэгжүүлэх үүднээс эрсдэлийн үнэлгээний дүнг үл харгалзан ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх саналыг удирдлагад танилцуулна.

Дөрөв. Газар дээрх шалгалт

4.1. Ажлын хэсэг нь ХЗХ-нд газар дээрх шалгалтыг хийхдээ дараах үзүүлэлтүүдийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

4.1.1. өөрийн хөрөнгийн хүрэлцээ

4.1.2. активын чанар

4.1.3. удирдлагын чадвар

4.1.4. ашигт ажиллагаа

4.1.5. төлбөр түргэн гүйцэтгэх чадвар зэрэг хамаарна.

4.2. ХЗХ-г хариуцсан улсын байцаагч, хянан шалгагч нь ажлын хэсгийг тайлан, мэдээллээр хангах, зайлшгүй шалгах шаардлагатай асуудлын жагсаалт, газар дээрх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлийн биелэлт зэргийг гаргаж өгнө.

4.3. Журмын 4.1-д заасан үзүүлэлтүүдийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгөхдөө үзүүлэлт бүрийн үндсэн болон харгалзах хүчин зүйлийг тооцох ба хүчин зүйл тус бүрт 1 буюу сайн, 2 буюу хангалттай, 3 буюу дунд, 4 буюу хангалтгүй, 5 буюу муу гэсэн үнэлгээг өгч, тухайн хүчин зүйлийн холбогдох хувиар жигнэж нийлбэрийг нь олох замаар үзүүлэлт бүрийн нэгдсэн үнэлгээг гаргана.

4.4. ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын байдалд журмын 7 дугаар хавсралт дахь хүснэгтийн дагуу холбогдох хувиар жигнэж 1 буюу сайн, 2 буюу хангалттай, 3 буюу дунд, 4 буюу хангалтгүй, 5 буюу муу гэсэн үнэлгээг өгөх байдлаар газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлгээ, дүгнэлт гаргана.

4.5. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг журмын 2 дугаар хавсралт, активын чанарын үзүүлэлтийг журмын 3 дугаар хавсралт, удирдлагын чадварын үзүүлэлтийг журмын 4 дүгээр хавсралт, ашигт ажиллагааны үзүүлэлтийг журмын 5 дугаар хавсралт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу тус тус үнэлж, дүгнэлт өгнө.

4.6. Журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлгээг өгнө. Нэгдсэн үнэлгээг дараах 5 түвшингээр ангилна. Үүнд:

4.6.1. нэгдсэн үнэлгээ 1-ээс 1.5 хүртэл байвал САЙН;

4.6.2. нэгдсэн үнэлгээ 1.6-аас 2.5 хүртэл байвал ХАНГАЛТТАЙ;

4.6.3. нэгдсэн үнэлгээ 2.6-аас 3.5 хүртэл байвал ДУНД буюу хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;

4.6.4. нэгдсэн үнэлгээ 3.6-аас 4.5 хүртэл байвал ХАНГАЛТГҮЙ буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй;

4.6.5. нэгдсэн үнэлгээ 4.6-аас 5 хүртэл байвал МУУ буюу төлбөрийн чадваргүй.

4.7. Ажлын хэсэг нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг гарган гишүүд гарын үсэг зурж, улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

4.8. Ажлын хэсэг нь шалгалт хийсэн ХЗХ-ны удирдлагад тухайн ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд өгсөн нэгдсэн үнэлгээ болон шалгалтын тайланг танилцуулна.

4.9. Шалгалтаар өгсөн нэгдсэн үнэлгээг тухайн ХЗХ хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд үнэлгээтэй танилцсанаас хойш 10 хоногийн дотор холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бичгээр гомдол гаргаж болно.

4.10. Дунд ба түүнээс доош нэгдсэн үнэлгээ авсан ХЗХ-нд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасан журмын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тав. Хариуцлага

5.1. Журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд
эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын
1 дүгээр хавсралт

“.....” ХЗХ-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-Д

Тайлангийн хариу

Танай ХЗХ нь 20... оны.... дугаар сарын-ний өдрийн байдлаар ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээллийг...../хугацаанд нь ирүүлсэн, хугацаа хоцроосон бол хэд хоног хоцроосныг бичих/ ирүүлсэн байна.

Хорооны Фин-А системд ирүүлсэн цахим тайлангаас харахад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАН- ГААР
А	ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ			
1	ХӨРӨНГИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (мянган төгрөг)			
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас бага	
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	30%-иас бага	
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА	ЗХШҮ	30%-иас бага	
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	60%-85%	
2	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	10%-иас бага	
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	20%-80%	
4	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	20%-иас бага	
5	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	10%-иас бага	
6	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	
7	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	ЗХШҮ	10%-иас их	
8	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ/ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	ЗХШҮ	5%-иас их	
9	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ/ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	ЗХШҮ	5%-иас их	
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ			
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	15%-иас бага	
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР			
	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)			
	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			

Танай ирүүлсэн тайлан, мэдээллээс үзэхэд тайлант хугацаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг..... (бүрэн хангасан эсэх, хэрэв хангаагүй бол ямар үзүүлэлтийг, хэдий хугацаагаар хангаагүйг дүгнэж бичих)

Хорооны 20.. оны ... сарын ...-ний өдрийндугаар тогтоолоор баталсан “Эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу /бага, дундажаас доогуур, дундаж, өндөр, маш өндөр/ эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Үнэлгээний тайланг хавсаргав.

Үнэлгээний дагуу арга хэмжээ (*ямар арга хэмжээ авсныг бичих*) авах болсныг үүгээр мэдэгдэж байна.

(Холбогдох хууль, журмыг хангаж ажиллаагүй бол тоочиж, ямар арга хэмжээ авах талаар нэгтгэн дүгнэж бичнэ бичнэ)

(Цаашид ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар зөвлөх)

Энэхүү мэдэгдэл болон бусад асуудлаар мэдээлэл авахыг хүсвэл 51-..... дугаарын утсаар зайны хяналт хариуцсан улсын байцаагч нартай холбогдох боломжтой болно.

..... ГАЗРЫН ДАРГА

/...../



ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

20... оны ... улирал

№	Эрсэдийн үнэлгээ	Ерөнхий мэдээлэл								
		ЗХШҮ	Ур дүн	Хангасан эсэх	Мян өвлөг	Өндөр	Дундаж	Дундаас доогуур	Бага	
1	Нийл гэмшүүлийн сөө	25								
2	Нийл хөрөнгө /төгрөг/	27,969,573,078								
3	Нийл зээл /төгрөг/	19,378,216,916								
4	Нийл халгаламж /төгрөг/	25,644,144,141								
5	Галнаас өвсөн зээл									
			Ухуулагууд		Эрсэдийн үнэлгээ					
6	Хоршоодогчдын өмч/ Нийл хөрөнгө	>8%	902,175,493	3.2%	Угүй		X			
7	Нөөцийн сан/ Нийл хөрөнгө	>5%	455,967,506	1.6%	Угүй		X			
8	ТТГЧ	>10%	8,014,238,051	31.3%	Тийм					X
9	Чанаргүй зээл/ Нийл зээл	<5%	814,404,034	4.2%	Тийм			X		
10	Зээлийн эрсэдийн сан/Нийл зээл	<5%	458,098,186	2.4%	Тийм				X	
11	Галнаас өвсөн зээл/Нийл хөрөнгө	<20%	-	0.0%	Тийм					X
12	Активын өгөөж/ Нийл хөрөнгө	>2%	446,207,986	1.6%	Угүй		X			
13	Үйл ажиллагааны зардал/Нийл хөрөнгө	<5%	1,655,330,722	5.9%	Угүй			X		
14	Үндсэн хөрөнгө/ Нийл хөрөнгө	<10%	1,645,651,420	5.9%	Тийм					X
15	Нийл зээл/ Нийл хөрөнгө	60%-85%	19,378,216,916	69.3%	Тийм					X
16	Нийл халгаламж/ Нийл хөрөнгө	60%-80%	25,644,144,141	91.7%	Угүй				X	
17	Халгаламж хамгаалалтын сан		113,991,877		Тийм					
18	Тогтворжилтийн сан		113,991,877		Тийм					
Эрсэдийн үнэлгээ										
Дундаж										

№	Ерөнхий мэдээлэл	ЭХШҮ	2017	2017	2018	2018	2018	2018	2019	2019	Эрсэлтийн задалгаа		
			III	IV	I	II	III	IV	I	II	Бусадтай	Тогтвортой	Буцаалттай
			Тренд анализ										
1	Нийт гишүүдийн тоо												
2	Нийт хөрөнгө											X	
3	Нийт зээл											X	
4	Нийт залгалас											X	
5	Гаднаас авсан зээл											X	
6	Хөршлөгсүүдийн өсч/ Нийт хөрөнгө	>8%	1.7%	3.5%	2.2%	3.3%	3.6%	5.2%	1.3%	3.2%	X		
7	Нөөцийн сан/ Нийт хөрөнгө	>5%	1.0%	1.1%	1.1%	1.1%	1.1%	1.3%	1.3%	1.6%	X		
8	ТТГЧ	>10%	30.3%	29.5%	30.5%	36.9%	35.8%	48.6%	32.3%	31.3%		X	
9	Чанахгүй зээл/ Нийт зээл	<5%	0.8%	3.8%	2.9%	4.7%	3.4%	3.9%	3.7%	4.2%		X	
10	Зээлийн эрсэлтийн сан/Нийт зээл	<5%	0.6%	1.3%	1.1%	2.1%	1.6%	2.2%	2.3%	2.4%		X	
11	Гаднаас авсан зээл/Нийт хөрөнгө	<20%	10.1%	9.1%	8.2%	0.0%	0.0%	0.0%	2.4%	0.0%		X	
12	Активын өсөөж/ Нийт хөрөнгө	>2%	0.7%	2.3%	1.1%	2.2%	1.8%	3.9%	0.3%	1.6%	X		
13	Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<5%	4.9%	6.9%	2.7%	4.1%	5.2%	8.2%	3.3%	5.9%		X	
14	Үндсэн хөрөнгө/ Нийт хөрөнгө	<10%	5.4%	4.2%	3.2%	3.5%	3.1%	3.7%	5.0%	5.9%		X	
15	Нийт зээл/ Нийт хөрөнгө	60%-85%	66.1%	64.7%	65.1%	61.7%	57.5%	52.6%	64.1%	69.3%		X	
16	Нийт залгалас/ Нийт хөрөнгө	60%-80%	79.6%	79.8%	81.1%	87.9%	81.7%	83.1%	84.4%	91.7%	X		
17	Халгалмаг хэмжээний сан		0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%			
18	Тогтворжилтийн сан		0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%			
			Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Дүн- даж	Ерөнхий эрсэлтийн үнэлгээ		
												Тогт- вор- той	

Тайлбар, зөвлөмж

Тайлбар 1

.....харьцаа
Тайлбар, зөвлөмж:

Хувь
.....%

Тайлбар 2

.....харьцаа
Тайлбар, зөвлөмж:

.....%

Тайлбар 3

.....харьцаа
Тайлбар, зөвлөмж:

.....%

Тайлбар 4

.....харьцаа
Тайлбар, зөвлөмж:

.....%

Тренд анализ

Регистрийн дугаар:.....	Нэр:
Ерөнхий эрсдэлийн түвшин болон хандлага	
Хугацаа	20.... оны ... улирал
Эрсдэлийн түвшин	бага, дундажаас доогуур, дундаж, өндөр, маш өндөр /доогуур нь зурна үү/
Эрсдэлийн хандлага	Өсөлттэй, тогтвортой, бууралттай /доогуур нь зурна үү/

Үндсэн хөрөнгө / Нийт хөрөнгө




Тайлбар:

Чанаргүй зээл / Нийт зээл



Тайлбар:

Активын өгөөж / Үйл ажиллагааны зардал



Тайлбар:

Нийт хөрөнгө / Зээл / Хадгаламж / Гаднаас авсан зээл



Тайлбар:

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд
эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын
2 дугаар хавсралт

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Хоршоологчдын өмчийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	30%	тогтмол биелүүлдэг	3-аас доошгүй улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсхүл улирал ээлжлэн биелүүлсэн	сүүлийн 3 улирал дараалан биелүүлээгүй	сүүлийн 3-аас дээш улиралд дараалан биелүүлээгүй	
1.2	Нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	20%	тогтмол биелүүлдэг	3-аас доошгүй улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	сүүлийн 3 улирал дараалан биелүүлээгүй	сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
1.3	Нөөцийн сангийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	30%	тогтмол биелүүлдэг	3-аас доошгүй улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	сүүлийн 3 улирал дараалан биелүүлээгүй	сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Өөрийн хөрөнгөтэй холбогдон гарсан хууль, журмыг зөрчсөн эсэх	20%	зөрчөөгүй	зөрчлийг өдөр тутмын үйл ажиллагааны явцад засах боломжтой	зөрчил гаргасан ба түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	удаа дараа зөрчил гаргасан, түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	зөрчил нь санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа	
ҮНЭЛГЭЭ		100%						

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд
эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын
3 дугаар хавсралт

АКТИВЫН ЧАНАР

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Цэвэр зээлийн өрийн үлдэгдэл нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	15 %	Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа	Зохистой түвшингээс дээш, доош 0.5 функтээр зөрүүтэй	Зохистой түвшингээс дээш доош 1.0 функтээр зөрүүтэй	Зохистой түвшингээс дээш, доош 1.5 функтээр зөрүүтэй	Зохистой түвшингээс 1.6-аас дээш, доош функтээр зөрүүтэй	
1.2	Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	15 %	5 хувь хүртэл	6-10 хувь хүртэл	11-30 хувь хүртэл	31-50 хувь хүртэл	51 хувь ба түүнээс дээш	
1.3	Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	15 %	100 хувь байгуулсан	91-ээс дээш хувь байгуулсан	71-90 хувь байгуулсан	51-70 хувь байгуулсан	50 хувь хүртэл байгуулсан	
1.4	Нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дүн нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	15 %	Нэгтгэлийн дундаж хувиас хамгийн бага	Нэгтгэлийн дундаж хувиас бага	Нэгтгэлийн дундаж хувьтай тэнцүү	Нэгтгэлийн дундаж хувьтай их	Нэгтгэлийн дундаж хувиас хамгийн их	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Нийт активт орлого авчирдаггүй активын эзлэх хувь хэмжээ	10 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	
2.2	Зээлийн бодлогын хэрэгжилт, Зээлийн хорооны үйл ажиллагаа буюу зээлийн эргэн төлөлт /шалгалт хамрах хугацаанд олгосон, төлөгдсөн зээлийн харьцаа/-ийн дагуу байгуулж, зарцуулсан эсэх	10 %	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 91-ээс дээш хувь байгуулсан	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 81-90 хувь байгуулсан	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 71-80 хувь байгуулсан	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 61-70 хувь байгуулаагүй	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 60-аас доош хувь 51-ээс дээш хувьд хүрсэн	
2.3	Чанаргүй активын нийт активт эзлэх хувь, түүний өсөлт, бууралтын шалтгааныг тодруулах, чанаргүй активыг барагдуулах талаар авсан арга хэмжээ, өр барагдуулж буй үйл ажиллагаа	5 %	Арга хэмжээ авсан, чанаргүй актив буурсан	Арга хэмжээ авсан, чанаргүй актив өсөөгүй	Арга хэмжээ авсан, өр барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа	Арга хэмжээ авсан өр барагдуулах арга хэмжээ аваагүй	Арга хэмжээ аваагүй, чанаргүй актив нэмэгдсэн	

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд
эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын
4 дүгээр хавсралт

УДИРДЛАГЫН ЧАДВАР

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТ ТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТ ГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Энэхүү журмын бусад 4 үзүүлэлтийн дундаж үнэлгээ /арифметик дундажаар тооцоолно/	40 %						
1.2	Үйл ажиллагааны зардлын үйл ажиллагааны орлогод эзлэх хувийн жин	25 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Хорооноос газар дээрх шалгалтын үр дүнгээр авсан арга хэмжээний биелэлт	5 %						
2.2	Эдийн засаг болон санхүүгийн салбарт гарч байгаа өөрчлөлтөд зохицуулан зөв зохистой шийдвэр гаргадаг эсэх /шалгалт хамаарах хугацаанд гаргасан шийдвэрүүд, түүний үр дүн/	5 %						
2.3	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгуулах талаар арга хэмжээ авдаг эсэх /дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/	5 %						
2.4	Удирдлагын мэдээллийн систем бүрэлдэн бий болсон эсэх /ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаархи мэдээллийг хэрхэн цуглуулдаг, шаардлагатай бүх мэдээллийг хамардаг, мэдээллийн үнэн зөв эсэхэд хэрхэн хяналт тавьдаг/	5 %						
2.5	Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн дотоод дүрэм, заавар журмыг боловсруулж, тэдгээрийг мөрдөж байгаа эсэх	5 %						
2.6	Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, ажилтнууд нь албан тушаалаа урвуулан ашиглаж байсан эсэх	5 %						
2.7	Санхүүгийн тайлан, мэдээг зохих журмын дагуу зөв зохистой гаргадаг эсэх	5 %						
ҮНЭЛГЭЭ		100 %						

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд
эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын
5 дугаар хавсралт

АШИГТ АЖИЛЛАГАА

ХҮЧИН ЗҮЙЛ	ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ	
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Активын өгөөж (<i>Тайлант хугацааны татварын дараах ашиг/Нийт дундаж актив</i>)	25 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
1.2	Өөрийн хөрөнгийн өгөөж (<i>Тайлант хугацааны татварын дараах ашиг/өөрийн хөрөнгө</i>)	25 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
1.3	Активын өгөөжийн өсөлт, бууралт	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн их өссөн, бага буурсан	Нэгтгэлийн дундажаас дээгүүр өссөн	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур өссөн	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага өссөн, их буурсан	
1.4	Цэвэр хүүгийн зөрүүний харьцаа ((Хүүгийн орлого - Хүүгийн зардал)/Нийт дундаж актив)	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Пассив хөрөнгөд эзлэх хүүд мэдрэмж багатай эх үүсвэр	20 %	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажаас -, + 10 хувиар зөрүүтэй	Нэгтгэлийн дундажаас 20 хувь доогуур	Нэгтгэлийн дундажаас 20- оос дээш хувь доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
ҮНЭЛГЭЭ		100 %						

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 6 дугаар хавсралт

ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТ ТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх	45 %	Тогтмол биелүүлдэг	Сүүлийн 3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 3 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
1.2	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээл нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх	30 %	Тогтмол биелүүлдэг	Сүүлийн 3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсхүл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 3 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Авллага, өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацааны харьцаа	15 %	Харьцааг хангасан	1 жилээс дээш хугацааны дараа хүндрэл үүсэж болзошгүй	2 улирлаас 1 жил хүртэл хугацааны дотор хүндрэл үүсэж болзошгүй	2 улирлын хугацааны дотор хүндрэл үүсэж болзошгүй	1 улирлын хугацаанд хүндрэл үүсэж болзошгүй	
2.2	Бусдад төлөх өр төлбөрийн үлдэгдэл, төлбөр тооцоог хугацаанд нь төлдөг эсэх	10 %	Хугацаандаа төлдөг	1 жилээс дээш хугацаанд хүндрэл үүсэж болзошгүй	1 улирлаас дээш хугацаанд хүндрэл үүсэж болзошгүй	2 улирал саатуулсан	3-аас дээш улирал саатуулсан	
ҮНЭЛГЭЭ		100 %						

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 7 дугаар хавсралт

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

ДД	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ЖИГНЭХ ХУВЬ	ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ		ӨМНӨХ ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	ӨӨРЧЛӨЛТ
			Үзүүлэлтээр	Жигнэснээр		
1	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ	20.00 %				
2	АКТИВЫН ЧАНАР	20.00 %				
3	УДИРДЛАГЫН ЧАДВАР	30.00 %				
4	АШИГТ АЖИЛЛАГАА	15.00 %				
5	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР	15.00 %				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		100.00%				

Жич: Бууруулсан эсхүл дээшлүүлсэн үнэлгээ бүрийн харгалзах үндэслэлийг тодорхой зааж бичнэ.

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ/НЭР/

ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:/НЭР/